

ТАНИЛЦУУЛГА

*Онцгой албан татварын тухай хуульд
нэмэлт оруулах тухай*

Монгол Улсад импортоор орж ирсэн өндөр үнэлгээтэй суудлын автомашины тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь төгрөгийн ханш болон төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна. Статистик тоон мэдээллээс авч үзвэл 2023 оноос 2025 оны хооронд импортолсон нийт суудлын автомашины дунд гаалийн үнэ нь 360 сая төгрөг /ойролцоогоор 100.0 мянган америк доллар/-өөс давсан автомашины тоо 0.3 хувь буюу үнэмлэхүй бага хэсгийг эзэлж байгаа хэдий ч нийт импортолсон автомашины үнийн дүнд эзлэх хувь 18 хувь буюу харьцангуй өндөр байна.

Олон улсад орлогын болон хөрөнгийн татварын ачааллыг чинээлэг хүмүүст илүү өндөр хувиар ногдуулж, нийгмийн дундаж болон амьжиргааны түвшин бага иргэдэд татварын ачаалал бага үүрүүлдэг хандлагатай байдаг. Энэ нь өндөр орлоготой хэсэгт өндөр, бага орлоготой хэсэг бага татварын ачаалалтай байх сонгодог татварын системийн нэг хэлбэр бөгөөд энэхүү шаталсан татварын тогтолцооны хүрээнд дэлхийн зарим улс орнууд тодорхой үнийн дүнгээс дээш үнэлгээтэй суудлын автомашины хэрэглээнд ялгавартай татварын бодлогыг хэрэгжүүлж, тодорхой босго үнийн түвшнээс давсан хэсэгт нэмж албан татвар ногдуулдаг байна.

Тухайлбал, Австрали Улсад импортолсон суудлын автомашины гаалийн үнийн 91,387 америк доллар /2025-2026 оны төсвийн жилд тогтоосон хувь хэмжээ/-оос давсан хэсэгт нэмж 33 хувийн албан татварыг, Канад Улсад 100,000 канад доллар /2022 онд тогтоосон хувь хэмжээ/-оос давсан хэсэгт 20 хувийн албан татварыг тус тус ногдуулдаг. Улмаар тодорхой үнийн дүнгээс дээш үнэлгээтэй автомашинд нэмэлт татвар ногдуулах бодлого нь эдийн засгийн бодлогын хүрээнд төлбөрийн тэнцлийг хангаж орлогын тэгш бус байдлыг бууруулахад түлхэц болох зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг байна.

Иймд манай улсын хувьд дээрх зохицуулалтыг нэвтрүүлэх нь олон улсын чиг хандлагад нийцэхээс гадна эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах, төлбөрийн тэнцлийг хангах, татварын үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж, импортолсон суудлын автомашины гаалийн үнийн 100.0 мянган америк доллароос давсан хэсэгт нэмж 33 хувиар татвар ногдуулах зохицуулалтыг Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусган боловсрууллаа.

Тус арга хэмжээ хэрэгжсэнээр татварын шударга тогтолцоог бэхжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, гадагш чиглэсэн валютын урсгалыг бууруулах зэрэг эерэг ач холбогдолтой.

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл

Онцгой албан татварын тухай хуульд хэсэг нэмэх

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.10 дахь хэсэг нэмсүгэй:

“6.10.Импортолсон суудлын автомашины гаалийн үнийн 100.0 мянган америк доллароос давсан хэсэгт энэ хуулийн 6.3 дахь хэсэгт заасан хэмжээн дээр нэмж 33 хувийн онцгой албан татвар ногдуулна.”

Гарын үсэг